

МОНГОЛБАНКНЫ ТӨЛБӨР ТООЦОО, БҮРТГЭЛИЙН ГАЗАР

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨВ

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА

Өмнөх үг

Төлбөрийн картын судалгааны зорилго нь сүүлийн жилүүдэд Монгол улсад өргөн хэрэглэгдэж байгаа төлбөрийн картын хэрэглээний тоон үзүүлэлтүүдийг нэгтгэж, түүний өөрчлөлт ба өсөлтийг хэмжих явдал юм. Судалгааг төлбөрийн картын үйлчилгээ үзүүлдэг Монгол улсын 10 банкны 2005 оноос 2008 оны тоон үзүүлэлтэд тулгуурлан хийлээ. Түүнчлэн судалгааны тоо баримтууд давхардсан тоогоор тооцоологдсон болно.

Монгол улс дахь төлбөрийн картын зах зээл

1.1. Карт эзэмшигчид ба карт ашиглагчдын тоо

2005 оноос 2008 оны эцсийн байдлаар карт эзэмшигчдийн тоо (давхардсан тоогоор) 333 мянгаас 1,1 саяд хүрч жилийн дундаж өсөлт нь 54% -тай байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Карт эзэмшигчид, карт ашиглагчдын тоо
/2005 - 2008 он/

Он	Карт эзэмшигчдийн тоо	Өөрчлөлт (%)	Карт ашиглагчдын тоо	Өөрчлөлт (%)
2005 он	333,005		236,839	
2006 он	417,697	25.4%	310,238	31.0%
2007 он	691,903	65.6%	227,810	-26.6%
2008 он	1,182,526	70.9%	470,773	106.7%
Нийт өөрчлөлт:		54.0%		37.0%

* Карт ашиглагчид нь сард 5-аас доошгүй удаа гүйлгээ хийдэг карт эзэмшигчид юм.

Харин 2005 онд карт ашиглагчдын тоо (давхардсан тоогоор) 237 мянгаас 470 мянгад хүрсэн буюу 37%-иар өссөн боловч 2007 оны үзүүлэлтийг 2006 оныхтой харьцуулахад 26,6%-иар буурсан. Хүснэгтээс харахад карт ашиглагчдын жилийн дундаж өсөлт карт эзэмшигчдийн тухайн үзүүлэлтээс 17%-иар их байгаа нь картын ашиглалт нэмэгдэж байгааг илтгэж байна.

1.2. Төхөөрөмжийн тоо


Монгол улсын арилжааны банкууд картын төлбөр тооцоонд ПОС (POS – point of sale), ПОБ (point of banking), АТМ (automatic teller machine) төхөөрөмжүүдийг ашиглаж байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Төхөөрөмжийн тоо
/2005 - 2008 он/

Төхөөрөмжүүд	2005	2006	2007	2008	Өсөлт /2007-2008/	Жилийн дундаж өсөлт
ПОС терминал	1,154	2,191	2,852	6,358	122.9%	81.0%
ПОБ терминал	38	156	848	2,176	156.6%	303.6%
АТМ төхөөрөмж	35	85	125	346	176.8%	122.2%
Нийт:	1,227	2,432	3,825	8,880		168.9%

Картын төлбөр тооцоонд ашиглагдаж буй төхөөрөмжийн тоо хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. ПОС терминалын хувьд 2005 оноос 2008 онд 1,154-6,358 ширхэг болж, жилийн дундаж өсөлт 81.0%, ПОБ терминалын хувьд 38-2,176 ширхэгт хүрч, жилийн дундаж өсөлт 303.6%, АТМ төхөөрөмж 35-346 ширхэгт хүрч, жилийн дундаж өсөлт 122.2% -тай байна.

График 1. Төхөөрөмжийн тоо /2005 -2008 он/



ПОС терминалын тоог ПОБ, АТМ төхөөрөмжийн тоотой харьцуулахад харьцангуй олон бөгөөд жигд өсөлттэй байгаа бол ПОБ терминалын хувьд 2006 оноос 2007 онд огцом өссөн, АТМ төхөөрөмжийн хувьд аажим өсөлт ажиглагдаж байна. /График 1/

1.3. ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо, дүн

Банкуудын ПОС терминалаар хийгдсэн нийт гүйлгээний дүн болон тоог дараах хүснэгтээр авч үзье.

Хүснэгт 3. ПОС –ийн гүйлгээний тоо, дүн /2005 -2008 он/

Он	Хагас жил	Гүйлгээний дүн	Өөрчлөлт (%)	Гүйлгээний тоо	Өөрчлөлт (%)
2005 он	I	41,177,674,724.57		663,234.00	
	II	116,103,951,220.32		1,475,797.00	
	Нийт	157,281,625,944.89		2,139,031.00	
2006 он	I	215,543,611,058.01		2,571,955.00	
	II	407,735,909,744.68		2,231,941.00	
	Нийт	623,279,520,802.69	296%	4,803,896.00	125%
2007 он	I	459,245,951,697.56		2,492,635.00	
	II	211,856,330,315.33		1,015,786.00	
	Нийт	671,102,282,012.89	8%	3,508,421.00	-27%


2008 он	I	245,058,756,464.92		1,046,648.00	
	II	53,178,128,352.34		717,085.00	
	Нийт	298,236,884,817.26	-56%	1,763,733.00	-50%
Жилийн дундаж 2005 оноос 2008 он		437,475,078,394.43	83%	3,053,770.25	16%

ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 2005 оноос 2006 онд 157,2 тэрбум төгрөгөөс 623,2 тэрбум төгрөгт хүрч 296% ийн өсөлттэй байсан бол 2007 онд 671,1 тэрбум төгрөг болж 8%-иар өссөн дүнтэй байна. Харин 2007 оноос 2008 онд 298,2 тэрбумд хүрч 56%-ийн бууралттай байна. 2005 оноос 2008 оны жилийн дундаж дүн 437,4 тэрбум төгрөг буюу жилийн дундаж өсөлт 83%-тай байна.

ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний тооны хувьд 2005 онд 2,1 сая ширхэг байсан бол 2006 онд 4,8 сая ширхэгт хүрч, даруй 2 дахин өсчээ. Гэвч 2007 онд 3,5 сая ширхэг болж 27%-иар буурч, 2008 онд 1,7 сая ширхэг болж өмнөх оныхоос 50% -иар буурсан байна. 2005 оноос 2008 оны гүйлгээний тооны жилийн дундаж өсөлт 16%-тай байна.

2005 оноос 2008 оны эхний хагас жилийн ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн, тоог дараах графикаар харуулав. /График 2/

График 2. ПОС –ийн гүйлгээний тоо, дүн
/2005 -2008 он/



Дээрх графикаас харахад 2005 оноос 2006 онд ПОС гүйлгээний дүн, тоо хэмжээ өсч, 2007 оноос буурч, 2008 оны эхний хагаст дахин өссөн ч 2008 оны хоёрдугаар хагаст буурсан байна. 2008 оны үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан, харин 2007 оны сүүлийн хагас жилийн үзүүлэлтийг 2008 оны эхний хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад өсөх хандлагатай байна.

**Хүснэгт 4. ПОБ –ийн гүйлгээний тоо, дүн
/2005 - 2008 он/**

Он	Улирал	Гүйлгээний дүн	Өөрчлөлт(%)	Гүйлгээний тоо	Өөрчлөлт(%)
2005 он	I	6,125,425,836.00		67,910.66	
	II	6,471,524,212.20		68,499.10	
	Нийт	12,596,950,048.20		136,409.76	
2006 он	I	12,848,222,635.80		124,670.36	
	II	19,554,762,575.41		161,027.38	
	Нийт	32,402,985,211.21	157%	285,697.74	109%
2007 он	I	25,464,313,080.07		171,108.00	
	II	184,505,081,142.57		1,364,403.00	
	Нийт	209,969,394,222.64	548%	1,535,511.00	437%
2008 он	I	212,255,214,133.80		1,827,732.00	
	II	250,466,563,727.69		2,241,305.00	
	Нийт	462,721,777,861.49	120%	4,069,037.00	165%
Жилийн дундаж /2005 оноос 2008 он/		179,422,776,835.88	275%	1,506,663.88	237%

ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 2005 оноос 2006 онд 12,6 тэрбум төгрөгөөс 32,4 тэрбум төгрөгт хүрч 157%-ийн өсөлттэй байсан бол 2007 онд 209,9 тэрбум төгрөг болж 6,47 дахин өссөн дүнтэй байна. 2005 оноос 2007 оны жилийн дундаж дүн 850 тэрбум төгрөг буюу жилд дунджаар 3,7 дахин нэмэгдсэн байна.

ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээний тоо ширхэгийн хувьд 2005 онд 136,4 мянга байсан бол 2006 онд 285,7 мянга болж 2,1 дахин нэмэгдсэн байна. 2007 онд 1,5 сая ширхэгт хүрч 5,4 дахин өссөн. 2008 онд 4,1 сая ширхэгт хүрч өмнөх оны мөн үеэс 2,6 дахин нэмэгдсэн, гүйлгээний тооны хувьд жилийн дундаж өөрчлөлт нь 165 %-тай байна.

**График 3. ПОБ гүйлгээний тоо, дүн
/2005 - 2008 он/**




График 3-аас харахад ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээний дүн болон тоо ширхэг нь 2005 оноос 2007 оны эхний хагас жилд харьцангуй жигд түвшинд байсан бол 2007 оны эхний хагасаас сүүлийн хагаст огцом өсчээ. 2008 онд гүйлгээний дүн, тоо ширхэг өсч байгаа нь нэгж гүйлгээний мөнгөн дүн өсч байгааг илэрхийлж байна.

**Хүснэгт 5. АТМ гүйлгээний тоо, дүн
/2005 -2008 он/**

Он	Хагас жил	Гүйлгээний дүн	Өөрчлөлт(%)	Гүйлгээний тоо	Өөрчлөлт(%)
2005 он	I	5,289,737,994.20		99,839.00	
	II	30,302,593,830.70		530,573.00	
	Нийт	35,592,331,824.90		630,412.00	
2006 он	I	36,874,900,363.20		599,705.00	
	II	46,030,934,050.29		835,558.00	
	Нийт	82,905,834,413.49	133%	1,435,263.00	128%
2007 он	I	58,337,113,474.90		1,097,335.00	
	II	114,324,742,086.60		2,342,690.00	
	Нийт	172,661,855,561.50	108%	3,440,025.00	140%
2008 он	I	321,643,895,076.00		3,871,362.00	
	II	170,694,096,110.00		5,275,048.00	
	Нийт	492,337,991,186.00	185%	9,146,410.00	166%
Жилийн дундаж /2005 оноос 2008 он/		195,874,503,246.47	142%	3,663,027.50	144%

АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 2005 оноос 2006 онд 35,6 тэрбум төгрөгөөс 83,0 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 133%-ийн өсөлттэй байсан ба 2007 онд 172,6 тэрбум төгрөг болж 108%-иар, 2007 оноос 2008 онд 172,6 тэрбум төгрөгөөс 492,3 тэрбум төгрөгт хүрч 2,85%-иар тус тус өссөн байна. 2005 оноос 2008 оны жилийн дундаж гүйлгээний дүн 196 тэрбум төгрөг буюу жилийн дундаж өсөлт 142%-тай байна.

АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо ширхэгийн хувьд 2005 онд 0,6 сая ширхэгээс 2006 онд 1,4 сая ширхэгт хүрч 128%-иар, 2007 онд 3,4 сая ширхэгт хүрч 140%-иар тус тус өссөн. 2008 онд 9,1 сая ширхэгт хүрч өмнөх оны мөн үеэс 2,6 дахин нэмэгдсэн байна. Харин гүйлгээний тооны жилийн дундаж өсөлт 144%-тай байна.

График 4. АТМ гүйлгээний тоо, дүн
/2005 - 2008 он/




График 4-өөс харахад АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн ба тоо хэмжээ нь 2005 оноос 2007 оны эхний хагас жил хүртэл жигд өсөлттэй байсан бол 2007 оны эхний хагасаас огцом өсч, 2008 онд 9,1 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна.

Хүснэгт 6. ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр
хийгдсэн гүйлгээний тоо, дүн
/2005 - 2008 он/

Д/Д	Он	ПОС -ын гүйлгээ		ПОБ -ын гүйлгээ		АТМ -ын гүйлгээ		Нийт	
		дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
		/тэрбум төгрөг/	/сая ширхэг/	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/
1	2005 он	157.3	2.1	12.6	0.1	35.6	0.6	205.5	2.9
2	2006 он	623.3	4.8	32.4	0.3	82.9	1.4	738.6	6.5
3	2007 он	671.1	3.5	210.0	1.5	172.7	3.4	1053.7	8.5
4	2008 он	298.2	1.8	462.7	4.1	492.3	9.1	1253.3	15.0
Нийт		1749.9	12.2	717.7	6.0	783.5	14.7	3251.1	32.9
Жилийн дундаж өсөлт (хувиар)		82.8%	16.0%	275.2%	237.3%	142.1%	144.4%	107.0%	77.0%

Хүснэгтээс харахад 2005 оноос 2006 онд ПОС терминалаар 466,00 тэрбум төгрөгийн 2,7 сая ширхэг гүйлгээ хийгдсэн бол 2006 оноос 2007 онд 47,82 тэрбум төгрөгөөр өсч, 1,3 сая ширхэгээр буурсан. 2007 оноос 2008 онд 372,9 тэрбум төгрөгийн 1,7 сая ширхэг гүйлгээгээр буурсан байна. 2005 онд 157,3 тэрбум төгрөгийн 2,1 сая ширхэг 2008 онд 298,2 тэрбум төгрөгийн 1,8 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь мөнгөн дүн 1,89 дахин нэмэгдэж, 0,3 сая ширхэгээр буурсан. Харин нэгж гүйлгээний дундаж дүн 2005 оноос 2008 онд 73,5 мянган төгрөгөөс 169,0 мянган төгрөг хүртэл 95,5 мянган төгрөгөөр өссөн байна.

2005 оноос 2006 онд ПОБ терминалаар 19,80 тэрбум төгрөгийн 0,2 сая ширхэг гүйлгээ, 2006 оноос 2007 онд 177,6 тэрбум төгрөгийн 1,2 сая ширхэг, 2007 оноос 2008 онд 252,7 тэрбум төгрөгийн 2,6 сая ширхэг гүйлгээгээр тус тус нэмэгдсэн байна. 2005 онд 12,6 тэрбум төгрөгийн 0,1 сая ширхэг 2008 онд 462,7 тэрбум төгрөгийн 4,1 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь мөнгөн дүнгээр 36,72 дахин нэмэгдэж, 4,0 сая ширхэгээр нэмэгдсэн байна. Харин нэгж гүйлгээний дундаж дүн 2005 оноос 2008 онд 92,3 мянган төгрөгөөс 113,7 мянган төгрөг хүртэл 21,4 мянган төгрөгөөр өссөн байна.

2005 оноос 2006 онд АТМ терминалаар 47,31 тэрбум төгрөгийн 0,8 сая ширхэг гүйлгээ, 2006 оноос 2007 онд 89,75 тэрбум төгрөгийн 2 сая ширхэг, 2007 оноос 2008 онд 319,67 тэрбум төгрөгийн 5,71 сая ширхэг гүйлгээ хийгдэж тус тус нэмэгдсэн байна. 2005 онд 35,6 тэрбум төгрөгийн 0,6 сая ширхэг 2008 онд 492,3 тэрбум төгрөгийн 9,1 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь мөнгөн дүн 13,83 дахин нэмэгдэж, 8,51 сая ширхэгээр нэмэгдсэн. Харин нэгж гүйлгээний дундаж дүн 2005 оноос 2008 онд 56,4 мянган төгрөгөөс 53,8 мянган төгрөг болж 2,6 мянган төгрөгөөр буурсан байна.

ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр 2005 оноос 2008 онд хийгдсэн нийт гүйлгээний тоо, дүнг авч үзэхэд ПОС терминалаар 1749,9 тэрбум төгрөгийн 12,2 сая ширхэг, ПОБ терминалаар 717,7 тэрбум төгрөгийн 6,00 сая ширхэг, АТМ төхөөрөмжөөр 783,5 тэрбум төгрөгийн 14,7 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна. Үүнээс үзэхэд ПОС болон АТМ гүйлгээний нийт тоо ширхэг нь ойролцоо байгаа боловч дүнгийн хувьд ялгаатай байна. Энэ нь ПОС терминалаар өндөр дүнтэй цөөн тооны, АТМ төхөөрөмжөөр бага дүнтэй олон гүйлгээ хийгдэж байгааг илтгэж байна. 2007 оноос ПОБ, АТМ гүйлгээний жилийн дундаж өсөлтийн хувь нь ПОС гүйлгээний тухайн үзүүлэлтээс өндөр байгаа нь банкууд ПОБ болон АТМ төхөөрөмжийн үйлчилгээнд илүүтэй анхаарч, ач холбогдол өгч байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл картаас бэлэн мөнгө гаргах зориулалт бүхий ПОБ, АТМ төхөөрөмжүүдийн ашиглалт нэмэгдэж байгаа буюу карт эзэмшигчид картан дахь мөнгөө бэлнээр авах сонирхол нэмэгдсэнийг харуулж байна.

1.4. Картын хэрэглээ орон нутагт

Банкууд нийт 21 аймагт картын үйлчилгээ үзүүлж байна. Доорх хүснэгтэд орон нутаг дахь карт эзэмшигчид, ашиглагчид, төхөөрөмжийн тоо хэмжээ болон улсын хэмжээний нийт үзүүлэлтэд тэдгээрийн эзлэх хувийг харуулав.

Хүснэгт 7. Орон нутаг дахь карт эзэмшигчид, ашиглагчид, төхөөрөмжийн тоо, харьцуулалт /2008 он/

Үзүүлэлт	Карт эзэмшигчдийн тоо	Карт ашиглагчдын тоо	Төхөөрөмжийн тоо		
			ПОС	ПОБ	АТМ
Нийт (орон нутаг)	306,105	195,726	1,242	1,537	238
Нийт (улс)	3,566,484	1,558,777	12,555	3,218	591
Харьцуулалт (%)	8.58	12.56	9.89	47.76	40.27

Хүснэгтээс үзэхэд хөдөө орон нутгийн карт эзэмшигчид нийт карт эзэмшигчдийн 8,58%-ийг, нийт карт ашиглагчдын 12,56%-ийг эзэлж байна.

Төхөөрөмжийн тоо хэмжээний хувьд нийт ПОС терминалын 9,89%, ПОБ терминалын 47,76%, АТМ төхөөрөмжийн 40,27%-ийг хөдөө орон нутагт ашиглаж байна.

Хүснэгт 8. Орон нутаг дахь ПОС, ПОБ, АТМ гүйлгээний тоо, дүн /2008 он/

Үзүүлэлт	ПОС гүйлгээ		ПОБ гүйлгээ		АТМ гүйлгээ	
	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/
Нийт (орон нутаг)	3.58	0.10	130.43	0.04	80.06	0.04
Нийт (улс)	1,749.90	12.22	717.69	6.03	783.50	14.65
Харьцуулалт (%)	0.20	0.81	18.17	0.66	10.22	0.27

Хүснэгтээс харахад орон нутагт ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг улсын нийт үзүүлэлтэд харьцуулахад ПОС гүйлгээний дүнгийн хувьд -0,2%, ПОБ - 18.17%, АТМ -10.22% - тай байна. Харин тоо ширхэгийн хувьд ПОС гүйлгээний дүнгийн хувьд -0.81%, ПОБ -0.66%, АТМ -0.27%-ийг тус тус эзэлж байна.

Сүхбаатар аймагт карт эзэмшигчидийн дансны дундаж үлдэгдэл хамгийн бага буюу 5,9 мянган төгрөг харин Увс, Дорноговь, Баянхонгор аймагт дундаж буюу 24 –өөс 29 мянган төгрөг, Орхон аймагт хамгийн өндөр буюу 90 мянган төгрөг байгааг нь Сүхбаатар аймгаас 15,25 дахин их дүнтэй байна. Орон нутагт Харин Улаанбаатар хотод 2,1 сая төгрөг буюу нийт үлдэгдлийн 77.8% -ийг эзэлж байна. /Хүснэгт 9/.

Баянхонгор, Говь-Алтай аймгуудад 4 буюу 0,17%, Дорнод, Өмнөговь аймгуудад 15 буюу 0,63%, Дархан-Уул аймагт 49 буюу 2,07%, Орхон аймагт 63 буюу 2,66%, Улаанбаатар хотод 2,037 буюу 86.09% -ийг картаар үйлчлэгч байгууллагууд тус тус эзэлж байна. Улсын хэмжээнд давхардсан тоогоор КҮБ 2,366 байгаа бөгөөд орон нутаг 329 ширхэг буюу нийт КҮБ-ийн 13,90% байна.

**Хүснэгт 9. Картын дансны дундаж үлдэгдэл,
КҮБ-ийн тоо /хувиар, 2008 он/**

Д/Д	Хот, аймаг	Картын дансны сарын дундаж үлдэгдэл		КҮБ	
		дүн	хувиар	тоо	хувиар
1	Баянхонгор	29,417.75	1.08	4	0.17
2	Говь-Алтай	35,271.30	1.30	4	0.17
3	Архангай	16,554.87	0.61	5	0.21
4	Завхан	59,417.75	2.18	6	0.25
5	Хэнтий	33,034.00	1.21	7	0.30
6	Баян-Өлгий	15,061.12	0.55	8	0.34
7	Дорноговь	25,484.42	0.94	8	0.34
8	Төв	7,511.14	0.28	9	0.38
9	Дундговь	17,767.36	0.65	9	0.38
10	Булган	22,080.45	0.81	11	0.46
11	Сүхбаатар	5,928.16	0.22	13	0.55
12	Увс	24,030.98	0.88	13	0.55
13	Дорнод	19,455.19	0.72	15	0.63
14	Өмнөговь	33,542.54	1.23	15	0.63
15	Говь-Сүмбэр	14,444.10	0.53	16	0.68
16	Өвөрхангай	21,306.58	0.78	16	0.68
17	Хөвсгөл	47,603.04	1.75	18	0.76
18	Ховд	17,477.18	0.64	19	0.80
19	Сэлэнгэ	32,591.99	1.20	21	0.89
20	Дархан-Уул	34,206.41	1.26	49	2.07
21	Орхон	90,014.88	3.31	63	2.66
22	Улаанбаатар хот	2,117,986.84	77.86	2,037	86.09
Нийт		2,720,188.04		2,366	

1.5. Бусад гүйлгээ (интернэтээр хийгдсэн гүйлгээ, залилангийн гүйлгээ)

Техник, технологийн дэвшлийг бэлэн бус төлбөр тооцоотой хослуулан ашиглах болсон өнөө үед интернэтээр төлбөр тооцоог гүйлцэтгэх үйлчилгээ манай оронд шинээр нэвтрэн хөгжиж байна.

Дээрх үйлчилгээг нийт 3 банк нэвтрүүлсэн бөгөөд 2008 оны II хагас жилийн байдлаар 5,5 тэрбум төгрөгийн 35, 4 мянган ширхэг гүйлгээ хийгдсэн байна.

Банкуудын төлбөрийн картын бизнес өргөжихийн хирээр бэлэн бус төлбөр тооцоо, бэлэн мөнгө гаргах ажиллагааг ашиглан залилангийн гүйлгээ хийгдэх арга нарийсч, нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 10. Залилангийн гүйлгээ /2008 оны II хагас жил/

Залилангийн арга	Гүйлгээний төрөл	Гүйлгээ хийгдсэн орчин	Мөнгөн дүн
Гээгдсэн карт	Бэлэн бус	ПОС	2,467,848.00
Давхар уншуулсан	Бэлэн мөнгө гаргах ажиллагаа	АТМ	4,770,912.00
		ПОС	598,956.00
	Бэлэн бус	Интернэт	1,052,448.00
		ПОС	3,105,618.00
Хуурамчаар хийгдсэн карт ашигласан	Бэлэн бус	ПОС	3,784,384.00
Мэдээлэл алдагдсан	Бэлэн бус	Интернэт	73,498,836.00
		ПОС	4,118,532.00
Хамт ажилладаг ажилтан нь картыг хулгайлж АТМ -ээс мөнгө авсан.	Бэлэн бус	АТМ	360,000.00
Интернэтээр захиалсан	Бэлэн бус	Интернэт	13,461,010.00
АТМ-ээс хасалт хийгдсэн	Бэлэн мөнгө гаргах ажиллагаа	Интернэт	2,552,540.00
Хулгайлагдсан картаар	Бэлэн бус	КҮБ	262,900.00
			285,800.00
			238,800.00
			310,750.00
			24,990.00
			30,000.00
			260,000.00
			150,000.00
			180,000.00
Нийт /мянган төгрөгөөр/			112,6

Дээрх хүснэгтээс харахад нийт 112,6 сая төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 104,7 сая төгрөг буюу 92,9 % -ийг бэлэн бус, 7,9 сая төгрөг буюу 7,1% -ийг

гүйлгээ бэлэн мөнгөн гаргах гүйлгээ эзэлж байна. Интернэт, ПОС, АТМ –ээр хийгдсэн гүйлгээнүүд дээрх Мэдээлэл алдагдсан, хуурамч карт ашигласан, давхар уншуулсан гэсэн аргуудаар залилангийн гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь банкууд төлбөрийн картны мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, банкны ажилтнуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, картын төвийн үйл ажиллагааг 24 цагийн тасралтгүй ажиллагаанд шилжүүлэх, картаар үйлчлэгч байгууллагатай нягт хамтран ажиллах, ажилтнуудыг карт эзэмшигч, ашиглагчдыг зөв хэрэглээнд сургах зайлшгүй шаардлага гарч байгааг харуулж байна.

1.6. Картын үйлчилгээний төлбөр, шимтгэл

Банкуудын картын үйлчилгээний төлбөр, шимтгэлийг судалгаанаас харахад банкууд 2 болон түүнээс дээш төрлийн карт гаргаж байгаа ба картын төлбөр 6,000.00 аас 10,000.00 төгрөг, жилийн хураамж 1,000-аас 10,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

Харин нэгж гүйлгээний шимтгэл 40,00 төгрөг байна. Бэлэн мөнгө гаргах үйлчилгээний (АТМ) шимтгэл 0-оос 0.5% - тай байна.

Өмнөх судалгаанаас үзэхэд банкуудын гаргасан картаар үйлчлэх гэрээт байгууллагын тоо харилцан адилгүй байгаа ба 28-аас 300 орчим байгууллага байна. Эдгээр байгууллага картаар үйлчлүүлэгчийн нэгж гүйлгээнд 0.3-аас 10%-ийн урамшуулал, мөн банкууд картын төрлөөс хамааран картын үлдэгдэлд сар бүр 0.3-аас 0,5%-ийн хүү тооцох урамшууллыг карт эзэмшигчиддээ үзүүлж байна.

Нэг өдөрт картаар хийх гүйлгээний дүнгийн дээд хязгаарыг энгийн карт 1 сая, алтан карт 3 саяас 5 сая төгрөгөөр тогтоох, эсвэл карт эзэмшигчтэй байгуулах гэрээгээр тохиролцон тогтоох туршлага хэрэгжиж байна.

Төлбөрийн картын үйлчилгээний төлбөр, хураамжийг бууруулахад карт эзэмшигч, ашиглагчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд картын хэрэглээний орчинг бүрдүүлэх буюу банкууд картын нэгдсэн сүлжээнд холбогдон, картаар үйлчлэгч гэрээт байгууллагуудын тоо хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй.

II. Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд Монгол улс дахь картын төлбөр тооцооны хэрэглээ болон банкуудын картын төлбөр тооцооны үйлчилгээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор төлбөр тооцоог улам шуурхай болгох, энэ төрлийн хэрэглээг хөхүүлэн дэмжих, олон нийтэд мэдээллийн хэрэгслээр дамжуулж сургалт, сурталчилгааг зохион байгуулж соёлтой үйлчилгээг хэвшүүлэх зэрэг үр дүнтэй ажлыг нээлттэйгээр авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Карт эзэмшигч, ашиглагчдын тоо: Монгол улсад карт эзэмшигчдийн тоо жилд дунджаар 54%, ашиглагчдын тоо 37%-тай байна. Карт ашиглагчдын тоо 2007 онд буурсан, мөн карт ашиглагчдын өсөлт карт эзэмшигчдийн тооны өсөлтөөс бага хувьтай байгаа нь дараах шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

- картын үйлчилгээний орчин хязгаарлагдмал байгаа буюу карт эзэмшигчид төлбөрийн картаа ашиглан төлбөр тооцоо хийх боломж бага,
- картын давуу тал, түүнийг хэрхэн ашиглах талаарх мэдлэг карт эзэмшигчдэд дутмаг байгаа,
- карт ашиглагчаас картын төлбөр тооцоонд суутгадаг шимтгэл, мөн сүлжээнээс хамааран суутгагддаг шимтгэлүүд өндөр,
- картын төлбөр тооцооны нэгдсэн зохицуулалт байхгүй байгаа зэрэг болно.

Төхөөрөмжийн тоо: Картын төлбөр тооцоонд банкуудын ашиглаж буй төхөөрөмжийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Үүнээс ПОБ терминалын тоо жилд дунджаар 303,6%-ийн өсөлттэйгээр тэргүүлж байгаа ба АТМ 122.2%, ПОС 81.0% -ийн жилийн дундаж өсөлттэй байгаа нь Хаан банк картын төлбөр тооцооны төхөөрөмж, терминалуудын тоо нэмэгдүүлж, өргөнөөр хэрэглэх болсонтой холбоотой юм.

ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо, дүн: Нийт төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг авч үзэхэд жилээс жилд нэмэгдсэн боловч ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний тоо ширхэг болон дүн 2006 оноос буурсан, ПОБ, АТМ төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний хувьд 2007 оноос хойш огцом өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд карт эзэмшигчид картаар төлбөр тооцоо хийхээс илүү картаас бэлэн мөнгө гарган, бараа үйлчилгээний төлбөрт хэрэглэх болсонтой холбоотой.

Картын хэрэглээ хөдөө орон нутагт: Нийт карт эзэмшигчдийн 8,58%, нийт карт ашиглагчдын 12,59% нь хөдөө орон нутагт байна.

Төхөөрөмжийн тоо хэмжээний хувьд нийт ПОС терминалын 9,89%, ПОБ терминалын 47,76%, АТМ төхөөрөмжийн 40,27% нь хөдөө орон нутагт ашиглагдаж байна.

Орон нутагт ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнгээс харахад АТМ, ПОБ төхөөрөмжийн хэрэглээ өндөр байгаа буюу иргэд картнаас бэлэн мөнгө авч, төлбөр тооцоонд ашиглах сонирхол их байгааг харуулж байна.

Хүн ам цөөн, зах зээл нь нийслэл хотдоо төвлөрсөн манай орны хувьд харилцан гүйлгээ дамжуулах боломжгүй олон сүлжээ байгаа явдал нь системийн үр ашгийг бууруулж, хэрэглэгчдийн хувьд хүндрэл үүсгэн, улмаар төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг хязгаарлах замаар бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Монголбанк болон арилжааны банкууд хамтран бэлэн бус төлбөр тооцооны шинэ дэвшилтэд хэрэгслүүдийг нэвтрүүлэх, нийтийн хүртээл болгоход Санхүү дундын сүлжээг ашиглан картын клиринг хийх, түүний эрх зүйн орчинг бий болгоход дараах давуу талуудтай. Үүнд:

- Банкуудын нэгэнт их хэмжээний хөрөнгө оруулж бий болгосон сүлжээ, тоног, төхөөрөмж, хүний нөөцийн хуваарилалтыг илүү уян хатан ашиглах,
- Банкуудын тоног төхөөрөмжийн давхардлыг арилгаж үргүй зардлыг системийн хувьд багасгах,
- Карт эзэмшигчдийн тоо, хэрэглээ, гүйлгээний төрлийг улам бүр нэмэгдүүлэх замаар бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж банкууд мөнгөн татан төвлөрүүлснээр санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх